

**БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2023 оны 07 дугаар  
сарын 31-ны өдөр

Дугаар № А/223 А/314 Улаанбаатар  
хот

Оюутны талаар авах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны 111 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчийг харьяалал харгалзахгүйгээр халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулсугай.

2. 2023-2024 оны хичээлийн жилээс шинээр элсэн суралцах болон үргэлжлүүлэх суралцах суралцагчдаар эрүүл мэндийн даатгалын хураамжийг төлүүлэх, суралцагчдыг урьдчилан сэргийлэх, эрт ирүүлэх үзлэг, оношилгоонд заавал хамрагдахыг үүрэгжүүлэх, хяналт тавьж ажиллахыг их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын захирал нарт даалгасугай.

3. Хөгжлийн бэрхшээлтэй, бүтэн өнчин болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх боломжгүй суралцагчдын эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг батлагдсан төсвийн хүрээнд гаргаж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газар /Л.Лувсан/, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө, оруулалтын газар /О.Хуягцогт/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын 1-т заасан арга хэмжээг хугацаанд нь шуурхай, чанартай зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтийн тайланг 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яаманд тус тус ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын захирал нарт тус тус үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н.Нарангэрэл/-т тус тус үүрэг болгосугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

ЭРҮҮЛ-МЭНДИЙН  
САЙД



С.ЧИНЗОРИГ